



ДОРНОД АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/16

Чойбалсан

Хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1, 12.1.4, 13.7, 24.6.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/215 дугаар тушаалыг үндэслэн коронавируст халдвар /COVID-19/-ын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах зорилгоор ТУШААХ нь:

1.Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр Эрүүл мэндийн яамнаас нийлүүлэгдсэн эмнэлгийн нэг удаагийн хэрэгсэл, коронавируст халдвар илрүүлэх полимеразын гинжин урвалын шинжилгээний оношлуур, сорьц цуглуулахад шаардлагатай дагалдах хэрэгсэл, түргэвчилсэн оношлуурын хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Баталсан хуваарийн дагуу түгээлт хийж, хэрэглээнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Ахлах нягтлан бодогч Б.Батцэцэг, Эмийн чанар, аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн Х.Эрдэнэцэцэг нарт даалгасугай.

3.Нийлүүлэгдсэн оношлуурыг холбогдох журам, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу хөрөнгийн бүртгэлд авч, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга /Ч. Оюунтунгалаг/ -д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч. ОЮУНАА



|    |  |          |   |      |     |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |      |
|----|--|----------|---|------|-----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|------|
| 9  | Фильтертэй хошуу<br>200ul 1*96                         | 2-       | ш | 50   |     |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    | 50 |      |
| 10 | Ковид<br>түргэвчилсэн оношлуур /<br>jounstar-шүлсэнд / | илрүүлэх | ш | 2375 | 200 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 3000 |

ooOoo